



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг баталгаажуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жи Эн энд Ко” оюуны өмчийн итгэмжлэгдсэн товчооноос БНХАУ-ын Guandong Puss Investment компанийн нэр дээр бүртгэгдсэн 40-0019148 дугаартай “NOME” барааны тэмдгийг хүчингүй болгуулах тухай гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн Оюуны өмчийн газрын дэргэдэх Маргаан шийдвэрлэх комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолыг баталгаажуулсугай.

2. Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг баталгаажуулсантай холбогдуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Маргаан шийдвэрлэх комисс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

1118267027
6024983
ШТТ2054